



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1135

Улаанбаатар хот

### Нийслэлийн Өргөө амаржих газрын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жи Жи Ритэйл ХХК-ны хандивласан нийт 2,054,895.00 (хоёр сая тавин дөрвөн мянга найман зуун ерэн зуун тав) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Өргөө амаржих газар (Н.Батсайхан)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Өргөө амаржих газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
 даргын 2024 оньк... дүгээр сарын ...-ны  
 өдрийн... дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Өргөө амаржих газар

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр	
							нэгжийн үнэ	нийт дүн			
1	Шилэн хөргүүр	Xingx LSC198CF	2024	Сайн	ш	1	854,905.00	854,905.00	ЖИЖИ РИТЭЙЛ ХХК	Хандив	
2	Хөлдөөгч	Monel fr-15wh 150l	2024	Сайн	ш	1	699,990.00	699,990.00	ЖИЖИ РИТЭЙЛ ХХК	Хандив	
3	Ариутгагч	ZMP-88	2024	сайн	ш	1	500,000.00	500,000.00	ЖИЖИ РИТЭЙЛ ХХК	Хандив	
Машин, тоног төхөөрөмжийн дүн								2,054,895.00			
НИЙТ ДҮН											